



МОНГОЛ УЛСААС АВСТРАЛИ УЛСАД
СУУГАА ОНЦ БӨГӨӨД БҮРЭН ЭРХТ
ЭЛЧИН САЙД Р.БОЛД ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IV байр,
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2013.11.01 № 01/140

Зөрчлийг арилгуулах тухай

Монгол Улсаас Австрали улсад суугаа Элчин сайдын яамны 2012 он, 2013 оны эхний 9 сарын санхүүгийн тайланд хийсэн аудитын явцад дараахь зөрчил илэрлээ.

2013 оны 9 сарын байдлаар 528.3 мянган ам. долларын үндсэн ба үндсэн бус үйл ажиллагааны орлого оруулж үүний 415.8 мянган ам. долларыг үйл ажиллагаандаа зарцуулж, 112.5 мянган ам. долларыг улсын төсөвт төвлөрүүлэхээр төлөвлөсөн байна. 2013 оны эхний 9 сарын байдлаар нийт 481.2 мянган ам. долларын орлого оруулсан ба үүний 86.0 мянган ам. долларыг улсын төсөвт төвлөрүүлж, 26.5 мянган ам. долларыг дутуу төвлөрүүлсэн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т заасан “Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулахын тулд акт тавих, албан шаардлага өгөх...”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан “Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3.1.1-д “...алдаа зөрчлийг арилгуулахаар төрийн аудитын байгууллага холбогдох албан тушаалтанд албан шаардлага өгнө.” гэсэн заалтыг үндэслэн дээрх зөрчлийг арилгах албан шаардлагыг өгч байна.

Дээрх дутуу төвлөрүүлсэн 26.5 мянган ам. долларыг улсын төсөвт төвлөрүүлж, биелэлтийг 2013 оны 12 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Монгол Улсаас Австрали улсад суугаа Онц бөгөөд бүрэн эрхт Элчин сайд Р.Болд, нягтлан бодогч З.Баянмөнх нарт даалгав.

АУДИТОР  Ш.ИЧИНХОРЛОО

УХА0122

070427